



**ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ЗОХИУЦУУЛАЛТ, ДУЛААН ТҮГЭЭХ, ХАНГАХ ҮЙЛ
АЖИЛЛАГАА, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭ**

**УЛААНБААТАР
2018 он**

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

ЭРЧИМ ХҮЧНИЙ
ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧИД



ЭРЧИМ ХҮЧНИЙ
ХЭРЭГЛЭГЧ



Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах, үнэ тарифыг тогтоох, эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮНДСЭН ЗОРИЛГО

**ЭХЗХ-ны
дүрэмд**

Эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагаа

Эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах


Эрчим хүчний салбарын үр ашгийг дээшлүүлэх

Хөрөнгө оруулалтыг дэмжих,

Эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх

Хангагч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалахад чиглэсэн зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино

АГУУЛГА



1 | **ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

2 | **ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ**

3 | **ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН БАЙДАЛ**

4 | **УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН ТҮГЭЭХ, ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

5 | **ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ**

ДУЛААН ТҮГЭЭХ, ДУЛААНААР ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАНГАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ КОМПАНИУДЫН ТАЛААР



1 | ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН



□ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын
хуулиуд

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль

Монгол Улсын
Засгийн Газрын
ТОГТООЛ

- Эрчим хүчний зохицуулах хорооны дүрэм
- Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм
- Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм

ЭХЗХ-ны тогтоол

- Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын бодлого, чиглэл
- Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах журам
- Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох, үнэлэх журам

□ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬ

- 15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл
- 15.8.3. эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, диспетчерийн зохицуулалт хийх, **түгээх, хангах, борлуулах үйл ажиллагаа эрхлэх;**

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д Хуулийн этгээд дараахь үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

Үүнд:

1. цахилгаан үйлдвэрлэх;
2. дулаан үйлдвэрлэх;
3. цахилгаан дамжуулах;
4. дулаан дамжуулах;
5. диспетчерийн зохицуулалт хийх;
6. цахилгаан түгээх;
- 7. дулаан түгээх;**
- 8. эрчим хүчээр зохицуулалттай хангах;**
9. эрчим хүчээр зохицуулалтгүй хангах;
10. цахилгаан импортлох, экспортлох;
11. эрчим хүчний барилга байгууламж барих;
12. хийгээр хангах;

□ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ

2017 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Эрчим хүчний сайдын зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны тэмдэглэл:

"Цахилгаан, дулааны эрчим хүчээр хангах, түгээх тусгай зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн судалгаа, шинжилгээний асуудлыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Насантогтох танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны хангах, түгээх тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдтэй дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ хийхийг зогсоож, Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7 "дулаан түгээх", 12.1.8 "эрчим хүчээр зохицуулалттай хангах", 12.1.9 "эрчим хүчээр зохицуулалтгүй хангах" гэдэгт нийцүүлэн гэрээ байгуулж ажиллахыг "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК /Д.Бямба-Очир/-д,

2. Эрчим хүчний зохицуулах хорооны хангах, түгээх тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг эрчим хүчний зохицуулалтын хүрээнд хуульд нийцүүлэн гэрээгээр ажиллуулах боломжийн талаар тусгаж, мөрдүүлж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хороо /А.Тлейхан/-нд,

3. Дээрх үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Насантогтох/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Сандуйжав/ нарт тус тус үүрэг болгов" гэжээ.

САЙД



П.ГАНХҮҮ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРОО

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2017.05.30 № 7/5716

танай _____ -ны № _____ -т

Зөвлөмж хүргүүлэх тухай


Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд болон Улсын Их Хурлын гишүүдэд 2017 оны байдлаар нийслэл, орон нутгийн иргэдээс орон сууцны конторууд, эрчим хүчний байгууллагын үйл ажиллагаатай холбоотой олон өргөдөл ирлээ.

Халаалт муу, зохих градуустаа хүрдэггүй, халуун ус тасардаг, Орон сууцны конторууд мэргэжлийн тусгай зөвшөөрөлгүйгээр аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж, хэрэглэгчдээр цахилгааны төлбөрийг давхардуулан төлүүлсэн, мэргэжлийн бус хүн цахилгаан, ус хязгаарладаг, тасалдаг, конторууд хэрэглэгчийн зөвшөөрөлгүйгээр сууц өмчлөгчдийн өмнөөс даатгалын байгууллагатай гэрээ хэлцэл хийж, даатгалын хураамж суутгаж авдаг, гэртээ хүнгүй байсан зэрэг шалтгаанаар байцаагч нар цахилгаан, усны тоолуурын заалтыг таамгаар бичилт хийдэг, шинээр баригдсан барилгуудын ундны ус нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй, их хэмжээний зэвтэй гардаг зэрэг асуудлуудаар иргэдээс ирүүлсэн өргөдлийг Өргөдлийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд судлан үзээд Ус, цахилгааны тоолуур, төлбөр, үйлчилгээний асуудлаарх хэлэлцүүлгийг 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Төрийн ордонд зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны гишүүд, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Улаанбаатар хотын захирагчийн алба, Стандартчилал хэмжил зүйн газар, Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газар, Ус сувгийг удирдах газар, Эрчим хүчний зохицуулах хороо, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК зэрэг холбогдох байгууллагууд болон иргэдийн төлөөлөл оролцож саналаа илэрхийлсэн бөгөөд Байнгын хороо хэлэлцүүлэгт оролцогчдоос гарсан саналуудыг нэгтгэж Засгийн газар, Эрчим хүчний яам, Барилга хот байгуулалтын яам болон холбогдох бусад байгууллагуудад зөвлөмж хүргүүлж байгааг хүлээн авч, хэрэгжүүлэх арга хэмжээ авна уу.

Хүндэтгэсэн,

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.САРАНГЭРЭЛ

□ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Эрчим хүчний Сайдын зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаас гарсан 2 дугаар тэмдэглэлээр тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээдүүдтэй дулаан худалдах, худалдан авах гэрээ хийхийг зогсоох, Эрчим хүчний тухай хуульд нийцүүлж ажиллахыг “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-д, эрчим хүчний зохицуулалтын хүрээнд хуульд нийцүүлэн гэрээгээр ажиллуулах боломжийн талаар тусгаж, мөрдүүлж ажиллахыг манай Хороонд даалгасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо болон Улсын Их Хурлын гишүүдэд нийслэл, орон нутгийн иргэдээс орон сууцны конторуудын үйл ажиллагаатай холбоотой олон өргөдөл гомдол ирсэнтэй холбогдуулан манай Хороонд 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдөр зөвлөмж ирүүлсэн.

Уг зөвлөмжид тусгай зөвшөөрөлгүй хувийн хэвшлийн орон сууцны ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдүүдийг Эрчим хүчний тухай хуульд нийцүүлэх, хэрэгжилтийг хангах, тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, шинээр ашиглалтад орж буй нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барьсан тохиолдолд эрчим хүчний дэд станц, шугам тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх зэрэг асуудлыг тусгасан юм.

□ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Барилгачдын талбай 13, Засгийн газрын XII байр
Утас: 26-47-86, Факс: (976-51) 26-60-88
E-mail: info@inspection.gov.mn
http://www.inspection.gov.mn

2016.05.25 № 71136
танай _____ -ны № _____ -т

Гэрээт борлуулагчийн журмын
тухай

Танай байгууллагаас зохион байгуулж буй "Дулааны эрчим хүчний гэрээт борлуулагчийн журам"-ыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд манай байгууллагаас төлөөлөл орж, холбогдох санал, зөвлөмжийг тухай бүр өгч ажилласан болно.

Дээрх журмын үзэл баримтлал, утга агуулга нь орон сууцны ашиглалт, үйлчилгээ, эрчим хүчээр хэрэглэгчдийг хангаж буй иргэн, ахуйн нэгж байгууллагуудын тусгай зөвшөөрөлгүйгээр явуулж буй хууль бус үйл ажиллагааг хүлээн зөвшөөрсөн, цаашдаа нийтийн эзэмшлийн инженерийн шугам сүлжээний өмчлөл, ашиглалт, үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж байгаа бөгөөд "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалт "Энэ зүйлд заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ. Үүнд: 15.8.3 эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, диспетчерийн зохицуулалт хийх, түгээх, хангах, борлуулах үйл ажиллагаа эрхлэх", "Эрчим хүчний тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 12.1. Хуулийн этгээд дараахь үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Үүнд: 2.1.6.цахилгаан түгээх, 12.1.7.дулаан түгээх, 12.1.8.эрчим хүчээр зохицуулалттай хангах, 12.1.9.эрчим хүчээр зохицуулалтгүй хангах" заалтыг зөрчиж байна.

Цаашид орон сууцны ашиглалт, үйлчилгээ, эрчим хүчээр хангаж буй үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг нэгтгэх, сонгон шалгаруулалт явуулах, шаардлага хангахгүй аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг зогсоох, тэдгээр байгууллагуудад хамтарсан хяналт шалгалт хийх зэргээр тодорхой арга хэмжээг зохион байгуулж хууль зөрчсөн үйл

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНД

ажиллагааг таслан зогсоох, иргэдийн эрүүл, аюулгүй байдлыг хангуулах шаардлагатай байна.


Иймд дээрх журмын төслийг одоогоор дэмжих боломжгүй байна.

Хувийг: Эрчим хүчний яаманд

"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-д

Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газарт

ДЭД БҮЦТИЙН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Д.ЖАРГАЛ



МХЕГ-аас 2016 онд дулаан түгээх, хангах үйл ажиллагааг дээр дурьдсан хуулийн дагуу заавал тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд эрхлэх талаар албан бичиг ирүүлж гэрээт борлуулагчаар иргэн, хуулийн этгээдийг ажилуулах боломжгүй байгааг мэдэгдсэн.

□ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

“УБДС” ТӨХК-д 2017 онд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөлгүй иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж ажиллаж байсан нь тогтоогдсон. Тус компанид Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны зөвлөмж, Эрчим хүчний сайдын Зөвлөлийн хурлын шийдвэр зэргийг үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 107, 108 дугаар тогтоолуудаар “УБДС” ТӨХК-д дээрх асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэн ажиллах талаар үүрэг даалгавар өгсөн.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 107

Улаанбаатар хот

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах
зарим арга хэмжээний тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.23, 9.2, Засгийн газрын 2016 оны 132 дугаар тогтоолоор батлагдсан Эрчим хүчний зохицуулах хорооны дүрмийн 2.1.6, Эрчим хүчний сайдын зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэл, тус хорооны 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 144 дүгээр тогтоолоор батлагдсан “Эрчим хүчний зохицуулалтын хяналт шалгалтын журам”-ын 8.2 дах заалтыг тус тус үндэслэн, “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-д хийсэн хяналт шалгалтын дүнг хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК /Д.Бямба-Очир/-д үүрэг болгох нь:

1/ Эрчим хүчний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.12 дах заалтуудыг зөрчин тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй иргэн, сууц өмчлөгчдийн холбоо, аж ахуйн нэгжүүдтэй дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ хийж байсан үйлдлийг таслан зогсоож, цаашид уг асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэн ажиллах;

2/ Нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барихаар техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохдоо Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.13-д заасны дагуу нийтийн эзэмшлийн орон сууцны барилгуудын эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх нөхцөл шаардлага тавих;

3/ Төлбөрт үйлчилгээний болон ажиллагсдын цайны газрын зардлыг дулаан түгээх, хангах зардлаас тусад нь бүртгэж тайлагнах;

2. Дээр дурьдсан үүрэг даалгаврын биелэлтийг 2017 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Эрчим хүчний зохицуулах хороонд ирүүлэхийг “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК /Д.Бямба-Очир/-д, энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Хяналт шалгалтын хэлтэс /Э.Самдан/-т тус тус даалгасугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Д.БАССАЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН


Тусгай зөвшөөрөлгүйгээр 2016 онд 530 гаруй иргэн, хуулийн этгээд дулаан түгээх, хангах үйл ажиллагаа эрхэлж байснаас 54 хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгож, 5 хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авахаар материалын бүрдүүлэлт хийж байна. Мөн “УБДС” ТӨХК-иас 277 хэрэглэгчийг “ОСНААУГ” ОНӨААТҮГ-т, 188 хэрэглэгчийг тусгай зөвшөөрөлтэй хувийн орон сууц ашиглалтын компаниудад шилжүүлсэн байна. Шилжүүлсэн хэрэглэгчдээс буцаж ирсэн болон 10 Гкал/ц хүрээгүй боловч одоогоор үйл ажиллагаа эрхэлсээр байгаа 30 хуулийн этгээд “УБДС” ТӨХК-тэй гэрээ байгуулан Хорооны 2017 оны 373 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж байна. Эдгээр компаниудыг 2018-2019 оны халаалтын улирал эхлэхээс өмнө хуульд нийцүүлэх шаардлагатай байна.

ХУВИЙН ОРОН СУУЦНЫ КОНТОРУУДАД БОРЛУУЛЖ БУЙ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ТҮҮНИЙ ТӨЛБӨР ТООЦООГ ШАЛГАСАН БАЙДАЛ, ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

2016 онд дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөлгүйгээр хэрэглэгчдийг дулаанаар хангаж байгаа 222 иргэн, сууц өмчлөгчдийн холбоо, компанитай “Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ” байгуулж дулаанаар ханган ажиллажээ.

Ангилал	Дулаан түгээх, хангах үйл ажиллагаа явуулсан он																НИЙТ
	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016		
Компани	8		2	2	5	2	3	33	6	17	13	21	17	12	2	143	
СӨХ	5	3	3	1	3	1	1	14	4	2	1	1				39	
Иргэн	1		3		4			4	3	5		5	11	4		40	
	14	3	8	3	12	3	4	51	13	24	14	27	28	16	2	222	

“УБДС” ТӨХК-ийн борлуулалтын орлогын бүтэц
/мян.төг/




“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн түгээж буй дулааны 20 орчим хувийг, борлуулалтын орлогын 28%-ийг эзэлдэг, 90 гаруй мянган айл өрхийг халаалт, хэрэгцээний халуун усаар хангадаг.

ХУВИЙН ОРОН СУУЦНЫ КОНТОРУУДАД БОРЛУУЛЖ БУЙ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ТҮҮНИЙ ТӨЛБӨР ТООЦООГ ШАЛГАСАН БАЙДАЛ, ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж буй эдгээр иргэн, СӨХ, хуулийн этгээдэд “УБДС” ТӨХК-иас тоолуураар худалдан авч байгаа дулааны төлбөр, хэрэглэгчдэд задгайгаар худалдаж байгаа дулааны орлогын зөрүүгээр дунджаар 48% нь үлддэг гэсэн тооцоо гарч байна.

Ангилал	2016 оны ДЭХ-ний төлбөр, бичилтийн орлого		Зөрүү /мян.төг/	Хувийн конторт үлдэх хувь
	УБДС-ээс худалдан авч байгаа ДЭХ /мян.төг/	Хэрэглэгчдэд худалдаж байгаа ДЭХ /мян.төг/		
Компани	20,305,274.4	39,318,928.7	19,013,654.3	48%
Сууц өмчлөгчдийн холбоо	784,651.1	1,366,419.0	581,767.9	43%
Иргэн	525,752.5	878,412.4	352,660.0	40%
ДҮН	21,615,678.0	41,563,760.1	19,948,082.1	48%




2

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ



□ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

- Эрчим хүчний зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн талаар баримтлах зохицуулалтын бодлого чиглэлийг олон нийтэд нээлттэй, ил тод болгох зорилгоор холбогдох баримт бичгүүдийг боловсруулж батлан тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүрээнд мөрдүүлж байна.




- Тусгай зөвшөөрлийн өргөдөл, хүсэлтийг хуулийн шаардлагад нийцсэн байдлаар **цахим** хэлбэрээр авах боломжийг бүрдүүлсэн. Мөн 2015 оноос тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын тайланг **цахимаар** авч дүгнэж эхэлсэн.

□ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

ЭХЗХ нь 2001 оноос эхлэн Эрчим хүчний тухай хууль/ ЭХТХ/-ийн дагуу тусгай зөвшөөрлийн тодорхой орчинг бүрдүүлэн эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулж буй ашиглалтын зөвшөөрлүүдэд зохицуулалт хийж ажиллаж ирсэн.



□ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН E-LICENSE ЦАХИМ СИСТЕМ



Хуулийн
этгээд

Тусгай зөвшөөрөл
шинээр хүсэж өргөдөл
гаргана.

Тусгай зөвшөөрөл
сунгуулахаар өргөдөл
гаргана.

Олгосон ТЗНШ-ын
биелэлтийг гаргаж өгнө,
дүгнүүлнэ.



Хүснэгт зөвшөөрлүүдийг хүсэх боломжтой
Цахилгаан үйлдвэрлэх
Цахилгаан үйлдвэрлэх- сэргээгдэх эх үүсвэр
Цахилгаан үйлдвэрлэх- дамжуулах шугам, дэд станц
Цахилгаан үйлдвэрлэх- Дулааны станц

Цахилгаан үйлдвэрлэх
Цахилгаан үйлдвэрлэх- сэргээгдэх эх үүсвэр

Хангах

Хангах

Хангах

Хангах

УЛАХ ХОРОО



3 | ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН БАЙДАЛ

□ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН БАЙДАЛ


✓ Тусгай зөвшөөрөл олгохдоо:

Эрчим хүчний тухай хууль

Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын дүрэм, журмууд (10 Гкал/ц)


№	ТЗ олгоход баримтлах суурь зарчмууд	№	Тусгай зөвшөөрлийн нөхцлүүд
1	Эрчим хүчний хангамж хэрэглээний тэнцэл хангагдсан байх;	1	Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай тусгай зориулалтын технологийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бүрдүүлсэн байх;
2	Техникийн хувьд найдвартай, аюулгүй, үр ашигтай горим ажиллагааг хангасан байх;	2	Мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг аюулгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах дадлага, туршлага бүхий хүний нөөцийг бүрдүүлэх;
3	Эдийн засгийн хувьд үр ашигтай, хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа зохист хэмжээнд байх;	3	Үйлдвэрлэсэн, түгээсэн, хангасан эрчим хүчийг хэмжих баталгаажсан тоолуур, хэмжих хэрэгсэлтэй байх;
4	Байгаль орчинд сөрөг нөлөөгүй, цэвэр технологийг хэрэглэх буюу сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээ төлөвлөгдсөн байх;	4	Техникийн алдагдал, горим тооцоо, борлуулалт, хэрэглэгчийн үйлчилгээний програм хангамжууд, тайлагналын системтэй байх;
5	Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа явуулах техникийн, хүний нөөцийн, санхүүгийн чадавхтай байх;	5	Технологийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах багаж хэрэгсэл, машин механизмтай байх;
		6	Гарч болзошгүй аваарь, ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, аюулгүйн нөөцтэй байх;
		7	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөртэй байх, тэдгээрийг хугацаанд нь хэрэгжүүлэх;
		8	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангасан, эрүүл, аюулгүй ажиллах орчин нөхцлийг бүрдүүлсэн байх;

□ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН БАЙДАЛ




ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

ТЗ-ийн
төрөл - 11




ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ


Хуулийн этгээд- 182
Тусгай зөвшөөрлийн тоо- 351



□ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН БАЙДАЛ /дулаан түгээх, хангах/



-Хувийн хэвшлийн орон сууц ашиглалтын 56 компани



4

УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН ТҮГЭЭХ, ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН ХАНГАМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХАНГАМЖ ХЭРЭГЛЭЭ



ТӨВЛӨРСӨН ДУЛААН ХАНГАМЖИЙН СИСТЕМ
(дулааны ачаалал-**2020.4 Гкал/цаг**)




ХЭСЭГЧИЛСЭН ДУЛААНЫ СИСТЕМ (62 зуухны газар)
(дулааны ачаалал-**188.5 Гкал/цаг**)




БИЕ ДААСАН СИСТЕМ (дулааны ачаалал-**1331.3 Гкал/цаг**)

**Нийт
дулааны
ачаалал
2307.4
Гкал/цаг**

□ УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН ТҮГЭЭХ, ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА




Эх үүсвэрүүдийн эзлэх хувь



Гнийт= 25256 тн/ц

Эх үүсвэр	Оргил ачааллын үеийн G т/ц	Эзлэх хувь, %
ДЦС-2	1035	4.10%
ДЦС-3Д	4276	16.93%
ДЦС-3Ө	3820	15.13%
ДЦС-4	13639.5	54.01%
АмДС	2485	9.84%

Эх үүсвэрийн хүчин чадал (Гкал/ц)




Дулааны хэрэглээ (Гкал/ц)


Эх үүсвэрийн хүчин чадал 2014 онд 100 Гкал/ц, 2015 онд 480 Гкал/ц-аар нэмэгдэж 2165 Гкал/ц байгаа боловч холбогдсон хэрэглэгчдийн дулааны ачаалал 2016-2017 оны байдлаар 2020.4 Гкал/ц байна. Иймд төвлөрсөн дулаан хангамжийн систем 2018-2019 онд чадлын дутагдалд орохоор байна.

□ УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН ТҮГЭЭХ, ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


ДЦС-уудын ачааллын хувиарлалт




ТДХ-ийн түгээсэн дулаан (мян.Гкал)



Хэрэглэгчдийн ДЭХ-ний хэрэглээний бүтэц




Хэрэглэгчдийн ДЭХ-ний хэрэглээний бүтэц



№	Он	Дулаан түгээлт		Өсөлт %	Олгосон техникийн нөхцөл Гкал/ц	Шинээр холбогдсон хэрэглэгч Гкал/ц	Холбогдоогүй хэрэглэгч Гкал/ц
		мян.Гкал	мян.кВт.ц				
1	2011	4,655.1	5,413,881.3	-	269.7	62.2	207.5
2	2012	4,963.3	5,772,317.9	7%	170.5	75.8	94.7
3	2013	4,891.9	5,689,279.7	-1%	206.1	95.5	110.6
4	2014	5,045.8	5,868,265.4	3%	457.6	136.0	321.6
5	2015	5,483.7	6,377,543.1	9%	239.7	143.0	96.7
6	2016	5,783.7	6,726,443.1	5%	167.2	129.7	37.5
7	2017	5,806.1	6,752,494.3	0.4%	281.7	106.5	175.2
Дундаж		5,232.8	6,085,746.4	3%	1792.4	748.7	1043.7

□ УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН ТҮГЭЭХ, ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 2016 ОНД

- Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7, 12.1.8-д заасан дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй.



Үүнээс: • **УБДС** • **ОСНААУГ** • **ХХК**


- Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөлгүй орон сууцны ашиглалт, үйлчилгээ хариуцан ажиллаж байгаа.



• **64 ХОСК**

• **160 гаруй ХХК, СӨХ, иргэн**


□ УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН ТҮГЭЭХ, ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 2016 ОНД



□ УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН ТҮГЭЭХ, ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 2017 ОНД

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны зөвлөмж, Эрчим хүчний Сайдын зөвлөлийн 2017 оны 2 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн ЭХЗХ-ноос шаардлага хангасан хувийн хэвшлийн компаниудад тусгай зөвшөөрөл олгоод байна.


■ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ



■ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХААР БЭЛТГЭЖ БУЙ ХОСК-ИУД



■ ЦААШИД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ



□ УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН ТҮГЭЭХ, ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 2017 ОНД



5

ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ



□ ДҮГНЭЛТ


- Хувийн хэвшлийн дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч 56 компани нь 100 мянган хэрэглэгчдэд 1.2 сая Гкал дулаан түгээсэн байна. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн нийт түгээлтийн 20%-ийг эзэлж байна.
- Дулаан түгээх, хангах үйл ажиллагааны борлуулалтын орлого 2017 оны гүйцэтгэлээр 32.7 тэрбум төгрөг бол дулаан түгээх, хангах үйл ажиллагааны зардал 33.1 тэрбум төгрөг байна.
- Гидравлик тооцоо, горим ажиллагааны батлагдаж, хянагдсан карт, график байхгүй, ямар горимоор ажилладаг нь тодорхойгүй, худалдан авах дулааны эрчим хүчний хэмжээг гадна агаарын температураас хамааруулан тооцдоггүй, дулааны балансыг улирлаар гаргаж ЭХЗХ-нд ирүүлдэггүй.
- Компанийн хүний нөөц, техникийн (богино, дунд, урт хугацааны) бодлогын бичиг баримтыг стандартын дагуу боловсруулж мөрдөж ажиллаагүй.
- Эрчим хүч хэмнэх төлөвлөгөө, дулаан түгээх сүлжээний нэгж цахилгаан, нэгж ус, нэмэлт усны зарцуулалтыг тооцон гаргаж бууруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, мэдээ, тайлан, тооцоо судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж ирүүлдэггүй.
- Халаалт, хэрэгцээний халуун усны удирдлагын ECL төхөөрөмж дээр температурыг багасгаж тохируулдаг, өгөх шугамын таслах хаалтаар даралт зарцуулалтыг бууруулж батлагдсан график мөрдөж ажилладаггүй.

□ ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

- ✓ 2018 оны зорилтыг биелүүлж ажиллах, тусгай зөвшөөрөл олгогчийн шийдвэрийг дагаж мөрдөх, тайлан, мэдээ, тооцоо судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж ирүүлэх;
- ✓ Гидравлик тооцоо, худалдан авах дулааны эрчим хүчний хэмжээ, 2 дугаар хэлхээний горим тохируулгын тооцоог боловсруулж хангагч байгууллагаар хянуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;
- ✓ Сар бүр худалдан авахаар төлөвлөсөн дулааны хэмжээг хангагч байгууллагатай хийж буй дулаан худалдах, худалдан авах аж ахуйн гэрээндээ тусгаж, мөрдөх, ус дулаан дамжуулах төвүүдийн тоног төхөөрөмж, ажиллагаагүй тоног төхөөрөмжийг бүрэн ажиллагаанд оруулж цаашид автомат горимоор ажиллуулах;
- ✓ Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаа, техник технологи, боловсон хүчний чадавхыг сайжруулах ажлын төлөвлөгөө боловсруулж ТЗЭ-чид болон ТББ-уудтай хамтарсан уулзалт зөвлөгөөн зохион байгуулж нэгдсэн ойлголттой болох;
- ✓ Компанийн хүний нөөцийн, техникийн, санхүүгийн бодлогын бичиг баримтыг холбогдох стандартын дагуу боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;
- ✓ Хэрэглэгчийн дуудлага, гомдол маргааныг бүртгэх, бүрэн шийдвэрлэх программ хангамжийг нэвтрүүлж, диспетчерийн үйл ажиллагааг сайжруулах, хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хангах талаар ажил төлөвлөн зохион байгуулж, биелэлтийг тайлагнах;

□ ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

- Санхүүгийн тайлан бүртгэлийг тусгай зөвшөөрөл олгосон үйл ажиллагааны төрөл тус бүрээр, тусгай зөвшөөрөлд хамаарахгүй үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь хөтөлж, тайлагнах;
- Санхүүгийн программ хангамжтай болох, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэлийг хөтөлж тайлагнах, үргүй зардлыг бууруулах;
- Хэрэглэгчдийн ачаалал нь 10 Гкал/ц хүрсэн компаниуд ЭХЗХ-ноос дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл авч “УБДС” ТӨХК-тай 2018-2019 оны дулаан худалдах, худалдан авах гэрээгээ хийх.
- “Тусгай зөвшөөрлийн бодлого чиглэл”-д нийцэхгүй, хэрэглэгчдийн ачаалал 10 Гкал/ц-т хүрэхгүй байгаа хуулийн этгээдүүд нэгдэж 1 хуулийн этгээд болж дулааны ачааллаа 10 Гкал/ц хүргэн ЭХЗХ-ноос дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл авч “УБДС” ТӨХК-тай 2018-2019 оны дулаан худалдах, худалдан авах гэрээ хийх.
- “Тусгай зөвшөөрлийн бодлого чиглэл”-д нийцэхгүй, хэрэглэгчдийн ачаалал 10 Гкал/ц-т хүрэхгүй байгаа хуулийн этгээдүүд дулаан түгээх, хангах үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлж шугам сүлжээ тоног төхөөрөмжөө ашиглуулсан үйлчилгээний төлбөрийг Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11-д заасны дагуу тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчээс авах.
- Тусгай зөвшөөрөл олгосон компаниудын үйлчлэх хүрээг нарийвчлан тогтоож түүнд хяналт, тавих, өөрчлөх тохиолдолд Хорооны хурлаар хэлэлцэж шийдвэрлэж байх.



**ДУЛААН ТҮГЭЭХ, ДУЛААНААР
ЗОХИЦУУЛАЛТАЙ ХАНГАХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЭЛЖ БУЙ КОМПАНИУДЫН ТАЛААР**

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ КОМПАНИУДЫН ТАЛААР

/УБДС ТӨХК-иас ирүүлсэн судалгаа/

Тусгай зөвшөөрөлгүй дулаан түгээх, хангах үйл ажиллагаа эрхэлж буй 31 компани байна.

Үүнээс:

1. Тусгай зөвшөөрлийн холбогдох бичиг баримтыг бүрдүүлж ирүүлсэн 5 компаниас 4 хуулийн этгээд нь 10 Гкал/ц-аас дээш ачаалалтай, 1 хуулийн этгээд нь 10 Гкал/ц-т хүрэхгүй байна.
2. Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчрүү шилжиж буй 9 хуулийн этгээд, СӨХ байна.
3. Үйл ажиллагааг бусдад шилжүүлээгүй, дулааны ачаалал нь хүрээгүй 17 хуулийн этгээд байна.

1.ЭХЗХОРООНД МАТЕРИАЛАА ӨГСӨН КОМПАНИУД

ДД	Хэрэглэгчийн нэрс	Дулааны ачаалал (Гкал/ц)	2018-09-07-ны байдлаар Төлбөрийн	ЭХЗХ-нд хандсан байдал	Тусгай зөвшөөрөл авах ажлын хүрээнд хийгдэж байгаа ажлууд ирүүлсэн тайлбар
1	Ган инженеринг ХХК	10.80	19.223.738	Цахимаар болон цаасаар ирүүлсэн Хорооны хурлаар хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна.	Тусгай зөвшөөрлөө авахаар ЭХЗХороонд материалаа өгсөн байгаа
2	Бигкастел ХХК	11.03	252.647	Цахимаар болон цаасаар ирүүлсэн Хорооны хурлаар хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна.	Тусгай зөвшөөрлөө авна. Материал бүрдүүлэлт болсон байгаа. ЭХЗХорооны хурлын товыг хараад байж байна.
3	Эмпати хаус ХХК	10.70	0.00	Цахимаар болон цаасаар ирүүлсэн Хорооны хурлаар хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна.	
4	Камдер ХХК	12.72	2.005.486	Цахимаар хүсэлт ирүүлсэн бөгөөд цаасаар материалаа ирүүлэхээр бэлтгэж байгаа.	Тусгай зөвшөөрлөө авахаар ЭХЗХороонд материалаа өгсөн байгаа
5	Эрин барилга ХХК	8.50	0.00	Цахимаар болон цаасаар хандсан боловч шаардлага хангахгүй буюу 10 Гкал/ц хүрэхгүй байна.	Дулааны ачаалал хүрэхгүй байгаа учир 2018-2019 онд гэрээ хийхийг зөвшөөрөхийг хүссэн албан бичгийг ЭХЗХ-нд өгсөн.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ КОМПАНИУДЫН ТАЛААР

/УБДС ТӨХК-иас ирүүлсэн судалгаа/

2. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ КОМПАНИУДАД ШИЛЖИЖ БУЙ ХЭРЭГЛЭГЧИД

ДД	Хэрэглэгчийн нэрс	Дулааны ачаалал (Гкал/ц)	2018-09-07-ны байдлаар Төлбөрийн	ЭХЗХ-нд хандсан байдал	Тусгай зөвшөөрөл авах ажлын хүрээнд хийгдэж байгаа ажлууд ирүүлсэн тайлбар
1	Иргэн Б.Цэндмаагийн ҮОС	0.33	17.226		Тусгай зөвшөөрөлтэй "Хаусинг Холд"ХХК-д шилжихээр болсон
2	Үйлчин ХХК	0.75	772.789		ХҮТ-10-т шилжүүлэхээр бэлэн болсон.
3	Оргил 30 СӨХ	0.65	0.00		Тусгай зөвшөөрөл бүхий "Мон Ватер"ХХК-д шилжихээр материалаа бэлтгэж байгаа
4	Сакура констракшн ХХК	0.32	0.00		Тусгай зөвшөөрөл бүхий "Грийт лакс"ХХК-д шилжихээр материалаа бэлтгэж байгаа
5	Ахмадын хотхон - 1 ОНӨААТҮГ	1.97	0.00		ХҮТ-5 шилжихээр Нийслэлийн өмчийн харилцааны А/230 тушаалаар шилжиж байгаа.
6	Буянопэл ХХК	1.67	0.00		Тусгай зөвшөөрөл бүхий "МОНТС" ХОСК-д шилжэхээр болсон
7	Буянт Буман СӨХ	0.89	0.00		ХҮТ-5 шилжихээр бэлэн болсон
8	Бага тойруу 64 СӨХ	0.29	81.260.648		ХҮТ-5 руу шилжүүлэх тухай санлыг хот руу албан тоотор хүргүүлсэн байгаа. 2016 онд ХЦТ-ийг худалдан авах акт үйлдсэн байгаа.
9	Зайсан дулаан өргөө СӨХ	2.91	101.060		Нийслэлийн өмчид шилжүүлэх ажил хийгдэж байгаа

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ КОМПАНИУДЫН ТАЛААР

/УБДС ТӨХК-иас ирүүлсэн судалгаа/

3.ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД АЧААЛАЛ НЬ ХҮРЭЛЦЭХГҮЙ БАЙГАА ХЭРЭГЛЭГЧИД

ДД	Хэрэглэгчийн нэрс	Дулааны ачаалал (Гкал/ц)	2018-09-07-ны байдлаар Төлбөрийн	ЭХЗХ-нд хандсан байдал	Тусгай зөвшөөрөл авах ажлын хүрээнд хийгдэж байгаа ажлууд ирүүлсэн тайлбар
1	КСимс ХХК	18.70	0.00	Цахимаар болон цаасаар хандаагүй	Тусгай зөвшөөрлөө авахаар материал бүрдүүлж байгаа. Байгаль орчны үнэлгээнд саатаад байна. Ачаалалын тодорхойлолт манайхаас сая авсан.
2	Тунамал арвижих өргөө ХХК	7.68	26.115.680	Цахимаар хандсан боловч шаардлага хангахгүй байсан учир буцаасан.	Тусгай зөвшөөрлөө хүсэхээр материал бүрдүүлж байгаа.
3	Бат Зохиомж ХХК	3.99	259.549	Хэрэглэгчийн дулааны ачаалал хүрэлцэхгүй байгаа.	Тусгай зөвшөөрлөө авах гээд материал бүрдүүлж байна. Манайх барилга барьдаг компани юм чин тусгай зөвшөөрөл авахгүй бол болохгүй юм байна лээ. Орон сууцны ашиглалтыг хүлээлгэн өгснөөс хойш 3 жил ашиглалтыг хариуцан ажилладаг. Манайх Оршил группын охин компани. Тусгай зөвшөөрлөө авна. Одоо барьж байгаа барилгын ачааллыг нэмж 10 Гкалд хүргэж болох бол ачаалал хүрчихсэн. Нэмж болох үү.
4	Баян газрын хишиг ХХК	1.36	18.685.150	Хэрэглэгчийн дулааны ачаалал хүрэлцэхгүй байгаа. Өмнө нь ЭХЗХ-нд цахимаар хүсэлт ирүүлж байсан боловч шаардлага хангахгүй байсан учир буцаасан.	2 хүнтэй компани. Газар нэмж тусгай зөвшөөрлөө авна
5	Би би инженеринг ХХК	3.78	13.288.274	Цахимаар болон цаасаар хандаагүй	Ар жанарын УДДТ-ийн эзэмшигч. /үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ ирсэнг гэрээний каталогид хадгалсан/ Газар нэмж авч тусгай зөвшөөрлөө авна
6	Дэнж хотхон ХХК	4.90	171.874.280	Хэрэглэгчийн дулааны ачаалал хүрэлцэхгүй, "УБДС" ТӨХК-иас тодорхойлолт авч чадахгүй байгаа. Өмнө нь цахимаар нэг удаа хандаж байсан.	Тусгай зөвшөөрөл авах гэхээр газар өгөхгүй байна. Бид ХОС-ны ууган компанийн нэг. Хэн нэгэнд өгмөөргүй байна. Газар нэмж өгөөч. Болохгүй бол өөр нэг ХОСК-тай нэгдэж тусгай зөвшөөрлөө авна.
7	Ганманлай ХХК	2.79	83.925.503	Хэрэглэгчийн дулааны ачаалал хүрэлцэхгүй байгаа.	Танайх газар өгвөл нэмж авмаар байна. Өгөхгүй бол аваагүй газартай нэгдэж тусгай зөвшөөрлөө авна. Материал бүрдүүлээд явж байна. Танайх газар нэмж өгвөл бас өр нэмэгдэхгүй шүү дээ. Газар өгөхгүй байна. Манайх ХОС-ны ууган компани. Энэ хүртэл босгосон компани алдмааргүй байна. Тусгай зөвшөөрлөө болж өгвөл авахад газар нэмж өгөөч.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ КОМПАНИУДЫН ТАЛААР

/УБДС ТӨХК-иас ирүүлсэн судалгаа/

3. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД АЧААЛАЛ НЬ ХҮРЭЛЦЭХГҮЙ БАЙГАА ХЭРЭГЛЭГЧИД

ДД	Хэрэглэгчийн нэрс	Дулааны ачаалал (Гкал/ц)	2018-09-07-ны байдлаар Төлбөрийн	ЭХЗХ-нд хандсан байдал	Тусгай зөвшөөрөл авах ажлын хүрээнд хийгдэж байгаа ажлууд ирүүлсэн тайлбар
8	Цэцэн Бээс ХХК	4.72	33.548.898		Газар нэмж өгөөч. Танайхан газар нэмж өгөхгүй байна. Өрөө барагдуулаад тусгай зөвшөөрлөө авна.
9	Дай цэцэн ХХК	3.22	3.622.074	Хэрэглэгчийн дулааны ачаалал хүрэлцэхгүй байгаа. Өмнө нь ЭХЗХ-нд цахимаар хүсэлт ирүүлж байсан боловч шаардлага хангахгүй байсан учир буцаасан.	"Ачаалал хүрэхгүй байгаа. Тусгай зөвшөөрөлгүй гээд байр нэмж өгөхгүй байгаа. Танай энэ даалгаврыг биелүүлэх гэхээр шийдэж өгөхгүй байр өгөхгүй байна. Тусгай зөвшөөрөлгүй гэж хариу бичиж бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж байна. Газар нэмж авмаар байна." 3 жил болж байна. Нэг шийдэлд хүрэх байх.
10	Гурван оргил таун ХХК	3.47	0.00		Ачаалал хүрэхгүй байгаа.
11	Түмэн наяд хайрхан ХХК	2.51	68.903		Ачаалал хүрэхгүй байгаа.
12	Хаан Уул Өргөө ХХК	1.07	120.628.973		
13	Лхатонм сервис ХХК	4.25	20.867.788	Хэрэглэгчийн дулааны ачаалал	"Лхатонм", "ЭС ДИ сервис" ХХК-иуд нэгдэж тусгай зөвшөөрөл авахаар материалаа бүрдүүлж байгаа.
14	ЭС ДИ сервис ХХК	2.53	82.688	хүрэлцэхгүй байгаа.	
15	Ноёд Констракшн ХХК	2.43	0.00		Ачаалал хүрэхгүй байгаа.
16	Хилийн цэргийн 0288-р анги	2.30	184.221		Шугам сүлжээ тоног төхөөрөмжөө шилжүүлэх ТӨХорооны шийдвэрээ хүлээж байгаа.
17	Эрэл ХХК	0.22	0.00	Эрэл ХХК-ийн өөрийн хэрэглээ учир үйлдвэрийн дулааны гэрээтэй нийлүүлж хийх боломжтой ААН-ээр тооцох шаардлагатай.	Ачаалал хүрэхгүй байгаа.

2018 ОНЫ 08 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР УБЗАА-Д ХОСНААБ-УУДААС ИРҮҮЛСЭН НИЙТЛЭГ АСУУЛТ, АСУУДАЛ

ДД	Тулгамдаж буй асуулт	Тайлбар
1	Одоогоор суурилагдсан хүчин чадал 10 Гкал/цаг хүрэхгүй байгаа ч цаашид төлөвлөгдсөн барилгын ажлууд дуусвал 2019 онд ТЗ-өө авах боломжтой байна. Энэхүү байдлыг харгалзан үзэх боломжтой эсэх? /ЭХЗХ/	Тусгай зөвшөөрлийн бодлого чиглэлийн дагуу 10 Гкал/ц хүрээгүй бол ТЗ олгох боломжгүй тул 2018-2019 оны халаалтын улиралд өөр хуулийн этгээдтэй нэгдэж ТЗ авах эсвэл ТЗ-тэй хуулийн этгээдэд шилжүүлээд 10 Гкал/ц хүрсний дараа буцааж авахаар гэрээ хийж ажиллах боломжтой.
2	Шинэ хэрэглэгчийг хүлээн аваад ХСУХАТАУ33-д бүртгүүлээд, УБДС ТӨХК-ийн хэрэглэгчийн гэрээг шилжүүлэх гэхээр ТЗ-гүй учраас шилжүүлэхгүй, бүртгэхгүй байна. Үүнээс хамаарч ТЗ-ийн нөхцөл хангах бололцоогүй байна. Мөн олж ирсэн хэрэглэгчийг өөр конторт шилжүүлэх, танил компанидаа шилжүүлэх байдал байдаг?	2018 оны 9-р сарын 7-ны өдөр "УБДС" ТӨХК дээр болсон хурлаар олон жил үйл ажиллагаа явуулж байгаа хүний нөөц болон тоног төхөөрөмж нь өөрийн эзэмшилд байдаг компаниудын дулааны гэрээнд өөрчлөлт оруулах, хэрэглэгч нэмэх асуудлыг "УБДС" ТӨХК шийдвэрлэн ажиллахаар болсон.
3	Шинээр байр, хэрэглэгч нэмэхээр УБДС ТӨХК гэрээ хийж, ачаалал тооцож өгөхгүй байна? /УБДС ТӨХК/	
4	Уурын зуухтай байрны ачааллыг нэмж тооцохгүй байна? /ЭХЗХ/ /Нийслэлийн зохицуулах зөвлөл/	Эрчим хүчний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 заасан төвлөрсөн дулаан хангамж гэсэн нэр томъёонд хамаарахгүй хуулийн этгээдэд тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан тусгай зөвшөөрлүүдийг тухайн орон нутгийн зохицуулах зөвлөл тусгай зөвшөөрөл олгож үнэ тарифыг нь баталдаг. Иймд төвлөрсөн дулаан хангамжид холбогдоогүй хэрэглэгчийн дулааны ачааллыг нэмж тооцох боломжгүй.
5	Хүчин чадал хүрэхгүй байгаа хэд хэдэн газрууд нэгдэх гэхээр өр, авлага, өмч зэргээс хамаараад болохгүй байна.	Нэгдэж буй компаниуд Компанийн тухай хууль, аж ахуйн гэрээгээр тохиролцон үйл ажиллагаагаа нэгтгэх бүрэн боломжтой.
6	70/30 тарифаас шалтгаалан өр, авлага эрс нэмэгдсэн. Орлогоос биш, тоолуураар тооцоог хийх хэрэгтэй байна? /Дэнж хотхон ХХК, Ганманлай ХХК/	Эрчим хүчний зохицуулах хороон нь Эрчим хүчний тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон хэрэглэгчийн худалдан авах эрчим хүчний үнэ тарифыг батлах эрхтэй.
7	Толгой компанийнхаа охин компаний хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа учраас нэгдэх боломжгүй байдалд хүрээд байна? /ЭХЗХ/	Эрчим хүчний тухай хуулийн дагуу үйл ажиллагаагаа тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэн тоног төхөөрөмж, шугам сүлжээгээ ашиглуулсны үйлчилгээний төлбөр авах боломжтой.

2018 ОНЫ 08 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР УБЗАА-Д ХОСНААБ-УУДААС ИРҮҮЛСЭН НИЙТЛЭГ АСУУЛТ, АСУУДАЛ

ДД	Тулгамдаж буй асуулт	Тайлбар
8	Эрчим хүчний зохицуулах хорооны “10гкал/ цаг” босго нь хүчин төгөлдөр нь захиргааны хэм хэмжээний актаар бүртгэгдсэн эсэх ? /ЭХЗХ/	Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.19 дэх заалтаар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Хорооны 2014 оны 190 дүгээр тогтоолоор "Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын бодлого, чиглэл"-ийг баталсан бөгөөд уг бодлого чиглэл нь нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлэх шаардлагагүй.
9	УБДС ТӨХК-аас хийгдэж байсан “Гэрээт борлуулагчаар ажиллах журам”-ыг мөрдөн цаашид ажиллах хүсэлтэй байна? /УБДС ТӨХК/	Эрчим хүчний зохицуулах хороо, "УБДС" ТӨХК, МХЕГ, НЕТГ, "ОСНААУГ" ОНӨААТҮГ-ын төлөөлөл оролцсон ажлын хэсгийг Хорооноос 2016 онд байгуулж Эрчим хүчний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь заалтын дагуу судалгаа хийсэн боловч МХЕГ, ЭХЯ-наас гэрээт борлуулагч ажиллах боломжгүй Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйл, 15.8.3 дахь заалтын дагуу дулаан түгээх, хангах үйл ажиллагааг заавал тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд гүйцэтгэх тул Эрчим хүчний тухай хуулийн 17.3 дахь заалтыг хэрэгжүүлэх боломжгүй гэсэн дүгнэлтийг гаргасан байдаг.
10	Одоо байгаа хэрэглэгчдийн шугам сүлжээ, ЦТП-д маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн байна. Үүнийг хэрхэн яаж шийдвэрлэх вэ ? Одоо үүсээд байгаа өр, алдагдлыг өөрсдөө хариуцаад, хөрөнгө оруулалт хийсэн тоног төхөөрөмжөө өөр байгууллагад шилжүүлнэ гэхэд маш хүндрэлтэй нөхцөлд орох гээд байна	Эрчим хүчний тухай хуулийн дагуу үйл ажиллагаагаа тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэн тоног төхөөрөмж, шугам сүлжээгээ ашиглуулсны үйлчилгээний төлбөр авч уг асуудлыг шийдвэрлэх боломжтой.
11	Нэгдсэн байгууллагуудын хот суурин ус хангамжийн ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тусгай зөвшөөрөл авах шаардлага тавьсан энэ хэрэгжүүлэхэд хүндрэлтэй юм?	Нэгдэж буй компаниуд нь ХСУХАТАУЗЗ-өөс олгогдсон орон сууцны ашиглалт үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд бол заавал уг тусгай зөвшөөрлийг авах шаардлагагүй.